

“ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ, ЭРХ МЭДЛИЙН ТӨЛӨӨ ХӨДӨЛГӨӨНИЙГ БЭХЖҮҮЛЭХ НЬ”

Энэхүү чанарын судалгааг МОНФЕМНЕТ Үндэсний сүлжээний санаачлагаар Канадын Гадаад хэргийн яамны дэмжлэгтэйгээр Азийн сангийн хэрэгжүүлж буй “Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд 2022 оны 12 сараас 2023 оны 2 дугаар сарын хооронд хийж гүйцэтгэсэн.

МОНФЕМНЕТ Үндэсний сүлжээний 29 байгууллагын төлөөлөл бүхий ЦӨМ багийн судлаачид судалгааны 4 чиглэлд хуваагдан, оролцооны цоо шинэ аргаар судалгааг амжилттай хийж, үр дүнг танилцуулж байна.

Судалгааны 4 үндсэн чиглэлийг: i) Бичил бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд тулгамдаж буй асуудал, ii) Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд бүтцийн хүртээмж, iii) Хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрх ба шууд бус ялгаварлан гадуурхалт, iv) Бага насны хүүхэдтэй залуу эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломж гэж тодорхойлон 4 тусдаа сэдэвчилсэн кейс судалгаа хийсэн.

Судалгааг үйл ажиллагаанд чиглэсэн, оролцоонд тулгуурласан, феминист судалгаа (ФемПАР)-ны арга зүйд үндэслэн хийсэн. ФемПАР нь феминист идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын үнэт зүйл, зорилгод нийцсэн судалгааны арга зүй юм. ФемПАР нь эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах хөдөлгөөнийг хөгжүүлэх, эмэгтэйчүүдийн хүний эрхийг ахиулах зорилгыг дэмжих, тэгш бус байдлыг илрүүлэх аргуудыг ашигладаг. ФемПАР аргуудын нийтлэг зүйл нь нийгэмд эмэгтэйчүүдийн дуу хоолойг хүргэх, тэдэнд тулгарч буй бэрхшээл, бүтцийн саад бэрхшээл, туршлагыг харуулах зорилготой.

Феминист оролцооны арга нь эмэгтэйчүүдийн аж амьдралд хамгийн тод илэрч буй тэгш бус байдал, тулгамдсан асуудлуудыг эмэгтэйчүүд өөрсдөө тодорхойлж, илрүүлж, үнэлж, дүгнэж, хамгийн оновчтой шийдвэрүүд гаргуулах зорилготой хийгддэг жендэрийн дүн шинжилгээний нэг хэлбэр юм.

ФемПАР аргууд нь зорилтот бүлгийн ярилцлага, хувь хүний түүхийг өгүүлэх, өдрийн тэмдэглэл ашиглах, асуудлын танин мэдэхүйн зураглал, эрх мэдлийн зураглал, олон нийтийн бүлгийн зураглал зэргийг багтаадаг. Феминист хандлага гэдгийг эмэгтэйчүүдийн туршлагыг хүлээн зөвшөөрч, баталгаажуулж, судлаачид жендэрийн туршлагын талаарх мэдлэгийг хуваалцаж, хувь нэмрээ оруулдаг гэж шууд утгаар ойлгож болно.

Холбоо барих цахим хаяг: coordinator@monfemnet.org, monfemnetzz@gmail.com